

**ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2023 оны 05 дугаар сарын 17-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3-7

*1.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл /Засгийн газар
2023.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/* 3-6

*2.Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих
журмын тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.05.03-ны өдөр өргөн
мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/* 6-7

***Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны
05 дугаар сарын 17-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл***

Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны дарга Б.Баттөмөр ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 10 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 17 цаг 04 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Ш.Адьяаа, Б.Бейсен, Б.Энхбаяр.

Нэг.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл /Засгийн газар 2023.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Дэд дарга бөгөөд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Баасандорж, мөн газрын Хуулийн багийн ахлах зөвлөх Ч.Ариунхур, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Дондогмаа, Монгол Улсын Их сургуулийн Шинжлэх ухааны сургуулийн Улс төр судлалын тэнхимийн профессор Д.Бумдарь нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Н.Мөнхзэсэм, Д.Нарантуяа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Х.Энэбиш, референт Ц.Энх-Амгалан нар байлцав.

Төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнийн тавьсан асуултад Байнгын хорооны дарга Б.Баттөмөр хариулж, тайлбар хийв.

Б.Баттөмөр: Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт оруулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	6
Татгалзсан:	1
Бүгд:	7

85.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 18 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Дэд дарга бөгөөд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Баасандорж, мөн газрын Хуулийн багийн ахлах зөвлөх Ч.Ариунхур, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Дондогмаа, Монгол Улсын Их сургуулийн Шинжлэх ухааны сургуулийн Улс төр судлалын тэнхимийн профессор Д.Бумдарь нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Н.Мөнхзэсэм, Д.Нарантуяа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Х.Энэбиш, референт Ц.Энх-Амгалан нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 20 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 16 минут үргэлжилж, ирвэл зохих 10 гишүүнээс 7 гишүүн хүрэлцэн ирж, 70.0 хувийн ирцтэйгээр 17 цаг 20 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.БАТТӨМӨР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 05 дугаар сарын 17-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим
17 цаг 04 минут.

ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Баттөмөр: Өнөөдөр энэ одоо Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны хурал эхэлж байна. Дарааллыг танилцуулъя. Нийт оролцвол зохих гишүүдийн 60 хувь нь одоо ирсэн байна. Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя. Баттөмөр байна. Адьшаа гишүүнд хэл, Адьшаа гишүүн хуралдаа ирж суух хэрэгтэй. Баделхан гишүүн байна, Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн байна, Баярсайхан гишүүн одоо орж ирж байгаа байх гэж байна. Бейсен гишүүн байгаа, Бямбацогт гишүүн байна. Л.Энх-Амгалан гишүүн байна. Энхбаяр гишүүн байгаа юм уу? Энхбаяр гишүүн хуралдаа ирээрэй. Энхболд гишүүн байна.

Байнгын хорооны хуралдааны хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Хэлэлцэх асуудал 1 дүгээрт Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл, энэ ажлын хэсэг орж ирэхгүй юм уу? Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл Засгийн газар 2023 оны 5 дугаар сарын 3-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэх. 2 дахь асуудал нь бол Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төсөл. Монгол Улсын Засгийн газар 2023 оны 5 дугаар сарын 3-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг. Хэлэлцэх асуудлаас өөр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Нэг.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл /Засгийн газар 2023.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/

1-д Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэх талаар хэлэлцүүлэе. Ажлын хэсгийг танилцуулъя. Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Амарбаясгалан. Ганбат ЗГХЭГ-ын Тэргүүн дэд дарга Тэргүүн дэд дарга. Амарбаясгалан дарга ЗГХЭГ-ын дарга, Монгол Улсын сайд, Ганбат Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга, Баасандорж ЗГХЭГ-ын дэд дарга, Амарбат ЗГХЭГ-ын дэд даргын зөвлөх, Бумдарь МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Улс төр судлалын танхимын профессор, Дондогмаа ЗГХЭГ-ын Хууль, эрх зүйн газрын дарга, Ариунхур ЗГ-ын Хяналт хэрэгжүүлэх газрын Хуулийн хэлтсийн багийн ахлах зөвлөх гэсэн ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 41.1-д Байнгын хороонд Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцэж, санал, дүгнэлт гаргана. Дүгнэлтээ гаргана, санал, дүгнэлт гаргана. Монгол Улсын Үндсэн хуульд өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 13.2-т заасны бусад Байнгын хороо уг төслийн талаар санал, дүгнэлтээ Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэж, ТББХ-нд өгнө гэсэн тус тус заасан байгаа.

Хууль санаачлагчдаас асуулт асуух гишүүд нэрээ өгнө үү? Бат-Эрдэнэ гишүүнээр тасалъя. Бат-Эрдэнэ гишүүнд микрофон өгье.

Б.Бат-Эрдэнэ: Би Байнгын хороонд хандаж нэг зүйл хэлэх гээд байна. Одоо ингээд ЗГ-ын гишүүн гээд Их Хурал, Байнгын хороон дээр чинь одоо үг

хэлэх бололцоо их хязгаарлагдмал. Та нар ЗГ дээрээ асуудал ярь гээд байдаг. Тэгээд энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн асуудлыг ард нийт иргэд, сонгогчдын дунд хэлэлцүүлэг явуулахтай холбоотой бид нар нэлээн явлаа л даа. Орон нутагт бол амьдрал амаргүй хүнд байна. Ялангуяа энэ бараа бүтээгдэхүүний үнийн өсөлттэй холбоотой. Мэдээж ковид цар тахал, дайн бүс нутгийг хамарсан дайны нөхцөл байдал гээд олон хүчин зүйл нөлөөлж байгаа байх.

Гэхдээ бид нар дотооддоо энэ асуудлуудыг зохион байгуулах ялангуяа Улсын Их Хурал бол 3 нэр төрлийн бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтийг зохицуулах тухай ийм хууль бодлого гарсан. Энэ хуулийн бодлогын хэрэгжилт газар дээрээ бас хэрэгжиж өгөхгүй. Одоо нэг жишээ хэлэх юм бол гурилын үнэ нэмэгдээд байгаатай холбоотой ийм асуудлууд яригдаж байна. Бид нар бол ерөөсөө гурил, мах, шатахуун гэсэн ийм 3 гол нэрийн бүтээгдэхүүнийхийг л үнийн өсөлтөөс хязгаарлах тухай ийм асуудал тавьсан.

Нөгөө нэг зүйл нь бол юу байна. Цалин хөлстэй холбоотой. Цалин хөлсийг бол мэдээж одоо үнийн инфляц тийм ээ, үнийн хөөргөдөл бусад хүчин зүйлүүдтэй холбож үзэх ёстой байх. Яах вэ ер нь энэ валютын ханшийн энэ их алдагдал, уналт энэ тэр чинь бол ерөөсөө нөгөө Үнэ тогтворжуулах хөтөлбөр, тэгээд ипотека бусад ийм шалтгаануудаар бэлэн мөнгө нийлүүлсэнтэй холбоотой их огцом өөрчлөлтүүд гарсан шүү дээ. Та бид нар бүгдээрээ мэдэж байгаа. Тэгэхээр энэ юмнуудтайгаа уялдуулах байлгүй. Цалин хөлснийхөө асуудал дээр нэг Их Хурал анхаарахгүй бол Байнгын хороон дарга та бол эдийн засгийн хүн. Одоо бас Даргын дэргэдэх зөвлөл энэ дээр нэг жаахан анхаарал тавьж, энэ гаргасан бодлогуудаа хэрэгжүүлэх, шинээр ямар нэгдсэн бодлого хэрэгжүүлэх вэ гэдэг дээр нэг анхаарал тавихгүй бол үнэхээр амаргүй ийм нөхцөл байдалтай байна шүү.

Яах вэ манай Их Хурал үе үеийн парламентын нэг дутагдал бол Их Хурлын гишүүд энэ салбарын хуулийг санаачилж оруулж ирж байгаад ингээд энд тэндээс нь сэглэсээр байгаад хөрөөний ир гэдэг шиг одоо ийм болгоод хаячихсан. Тэгээд энэ нь эдийн засгийн олон хүчин юу үзүүлэлтүүдэд нөлөөлөөд ингээд явчихдаг. Тийм ээ. Хамгийн түрүүлээд л шүүхийнхний цалин нийгмийн баталгаатай холбоотой юмыг оруулж ирсэн. Тэгээд л дараа дараагаар нь ингэж оруулж ирсээр байгаад. Тэгээд ер нь хамгийн ёроолд нь бол энэ соёл урлагийн салбар, биеийн тамир спортын салбар гэдэг л 2 одоо үлдчихээд байгаа юм. Тэгээд соёл урлагийн салбарынхан бол ер нь эв нэгдэлтэй нэлээн асуудлаа тавьдаг ийм л улсууд л даа. Тэгээд тэрүүгээрээ жагсаал цуглаан хийгээд байх шиг байгаа юм.

Яах вэ манай биеийн тамирынхан бол тэгж чадна л даа. Манайх бол одоо том хүч байна шүү дээ. Зөвхөн одоо улсын хэмжээнд гэхэд 3 мянга гаруй жилдээ биеийн тамирын тэмцээн уралдаанд үзэгчдийг оролцуулахгүйгээр гэхэд 1 сая 100 мянган хүн 8 наснаас 80 насыг хүртэлх энэ орон зайд оролцож байгаа. Тэгэхээр бид нар асуудлыг тавиад ингээд янз бүрийн байдлаар л илэрхийлж болно доо. Ер нь 90 оны үед ч гэсэн бид нар бол тийм асуудал гаргаж байгаагүй. Манай тамирчид бол Спортын ордондоо, заал танхимдаа, стадиондоо энэ нийгмийн тогтвортой байдлыг хангах, өөрсдийнхөө хүлээсэн үүрэг, энэ биеийн тамирынхаа тэмцээн уралдаан, хийх ёстой ажлаа хийгээд л ингээд л үүргээ гүйцэтгээд л зогсож байсан улсууд. Одоо ч яг л тэгж л одоо зогсож байгаа улсууд.

Тэгэхдээ үнэхээр одоо амаргүй байна шүү. Яг энэ соёл урлагийн байгууллагынхантай адилхан хагас, бүтэн сайн амралт байхгүй. Ерөөсөө хагас, бүтэн сайн өдөр амралт байхгүй. Ялангуяа энэ биеийн тамир, спортын

аймаг, нийслэлийн биеийн тамирын спортын хороонуудад ажиллаж байгаа энэ биеийн тамирын мэргэжилтэн, албан хаагчид чинь бол цалин маш доогуур. Тэгээд энэ боловсролын салбар луу ерөнхий боловсролын сургуулийн биеийн тамирын багшаар чинь одоо шилжиж ажиллах гээд ингээд хошуураад байна шүү дээ. Тэгээд яагаад гэвэл нөгөө биеийн тамир, спортын аймаг нийслэлийн биеийн тамирын хороонд ажиллаж байгаа мэргэжилтэн одоо юу байдаг юм улсууд чинь цалин нийгмийн баталгаа нь их доогуур учраас. Тэгэхээр энэ асуудлыг нэг цогцоор нь авч үзэхгүй бол. Яах вэ зүгээр би биеийн тамир спортын салбарыг онцолж хэллээ.

Ер нь энэ салбар болгоны энэ цалин нийгмийн хамгаалалттай холбоотой гээд их зөрүү гарчихсан юмыг арилгах чиглэлээр давын өмнө арга хэмжээ авмаар байна. Одоо хөдөө нэг яригдаж байгаа юм бол энэ тэтгэвэр. Ноднин тэр тэтгэврийн шинэчлэлтэй холбоотойгоор ерөөсөө 30, 40 жил улсад ажилласан хүний тэтгэвэр 3, 4 жил ажилласан уу, ажиллаагүй хүний тэтгэвэр 2 нэгтгэгдсэн, яг ижил хэмжээнд болгочихсон энэ бол одоо асар одоо тэгш шударга бус ийм ялгааг бий болгочихсон байж байгаа юм. Тэгэхээр энэ зөрүүтэй байдлуудыг юуны өмнө одоо арилгах чиглэлээр анхаарал тавих. Би тэгээд Байнгын хорооныхоо даргад хандаж би энэ асуудлыг тавьж хэлж байгаа юм даа. Өөр юмгүй.

Б.Баттөмөр: Манай Бат-Эрдэнэ сайд бас маш чухал асуудлыг хөндөж тавьж гаргаж байна. Ер нь бол сая хийсэн уулзалтаар тавьсан асуудал бол үндсэндээ бараг 70, 80 хувь нь бол энэ цалин хөлстэй холбоотой, бараа бүтээгдэхүүний үнийн өсөлттэй асуудал байсан. Яах вэ иргэдийн хувьд бол тэр Үндсэн хуулийн өөрчлөлтийг зөв хийхийг бол дэмжиж байгаа. Тоон дээрээ бол асуудал байсан. Ер нь бол одоо манай статистикийнхны гаргаж байгаа

тооцоолоор сүүлийн 3 жилийн хугацаанд инфляц 34 хувь гэж байгаа юм л даа. Яах вэ дээ албан ёсны байгууллага гаргаж байгаа учраас энд итгэхээс өөр, итгэе гэж бодъё. Гэхдээ энэнээс илүү л дээ, хамаагүй илүү байгаа шүү дээ тийм ээ. Гурил яаж нэмэгдсэн байна, талх яаж нэмэгдсэн байна гэх мэтээр ингээд үзэх юм бол.

Тэгээд ингээд үзэх юм бол зөвхөн 34 хувийн инфляц гээд л ингээд л бодоход л 13 их наяд төгрөг нэмээд хүмүүсийн халааснаас гарчихсан байгаа байхгүй юу. Тэгээд энэ 13 их наяд төгрөг хаанаас гарч байна вэ гэвэл нөгөө хуримтлал. Тэгээд дээрээс нь зээл авч байна. Өр тавьж байна. Идэж уухаа хязгаарлаж байгаа ийм л нөхцөл байдал одоо үүссэн л байгаа юм л даа. Тийм учраас бол Монгол Улсын зах зээлийн эдийн засгийн харилцаанд бүрэн шилжээгүй байгаа. Бүгдийг нь зах зээлийн тэр үл үзэгдэгч гарт ингэж одоо найдаж хаях юм бол яг ийм одоо яаж байгаа юм. Тийм учраас төрийн оновчтой бодлого, зохицуулалтууд хэрэгтэй. Энэтэй бол тантай бол санал нэг байгаа.

Өчигдөр Монгол Улсын Ерөнхий сайдтай бид нар уулзсан. Бид нар одоо ингээд хоёр дахь хэлэлцүүлгийн үеэр тойргуудаараа явна. Тодорхой ЗГ-аас бол энэ цалин, тэтгэвэртэй холбоотой, тэгээд бараа бүтээгдэхүүний үнийн өсөлттэй холбоотой асуудлуудаар энэ Их Хурлын гишүүдэд тодорхой материал бэлдэж өгөхөд, өгнө гэж одоо өчигдөр ойлгосон. Төсөв бол Монгол Улсын төсөв бол эхний улирлын байдлаар их боломжийн сайн дүнтэй гарч байгаа юм. Зөвхөн 1 дүгээр улирал гэхэд юу эхний 4 сард гэхэд 7,1 их наяд төгрөгийн төсвийн орлого цугларсан. Энэ нь төлөвлөснөөс 1 их наядаар давж байгаа шүү дээ. Тийм учраас бидэнд бол боломж байна. Тэгэхдээ энэ жижиг олж байгаа, энэ гарч байгаа энэ ололт, энэ амжилт маань бол цаашдын хөгжлийн суурь байгаасай, энэ ололт цаашидаа ингээд он дуустал ингээд яваасай ийм хүсэл

хүлээлтүүд бол байгаа гэдгийг өнөөдөр хэлье гэж бодож байгаа юм.

Ер нь бол Их Хурлын гишүүдийг бол тойрогт очихоор бол ерөөсөө л ярьж байгаа л юм энэ та нар 76 одоо ингээд хийсэнгүй. Бид бол ЗГ-ын ажилд тэр болгон оролцоод байдаггүй. ЗГ-т ажиллах бүх нөхцөлийг нь бүрдүүлж өгсөн. Тийм учраас бол Их Хурлын зүгээс бол ЗГ-т бол тавих шаардлага бол өндөржүүлэх шаардлагатай. Одоо энэ бараа бүтээгдэхүүний үнийн өсөлттэй холбоотой. Яах вэ импортлогдсон нь бол одоо биднээс шалтгаалахгүй байгаа юм бас байна л даа. Шалтгаалаад байгаа ч юм байгаа шүү дээ. Ер нь гурил гэхэд л бол бүгдийг нь хувьд өгчихсөн, буцаад эргээд хувийн монопол тогтчихсон байгаа шүү дээ. Яг гурил дээр гээд л тэгэхэд бол. Гэх мэтийн ийм одоо бид нар үзмээр юмнууд их байгаа юм. Тэгээд энийг бол яах вэ бид нар бас бодлогын хэмжээнд Даргын зөвлөл дээр бас энэ асуудлуудыг ярина.

Ингээд энэ хэлэлцүүлгийн дараагаар маргааш нөгөөдөр бол хоёр дахь хэлэлцүүлэг хийгдэнэ. Энэний дараагаар тойрог тойрогт явах тодорхой мэдээлэлтэй явна гэж бодож байгаа. Тодорхой арга хэм хэмжээнүүд авагдана гэж ингэж ойлгож байгаа. Ер нь ахмадуудын хувьд бол үнэхээр шударга биш байгаа. Одоо ингээд энэ Монголын төрд олон жил ажилласан бидний энэ баялгийг бий болгосон хүмүүс бол 500 мянган төгрөгийн л тэтгэвэртэй байгаа шүү дээ. Тэгтэл одоо сүүлийн үед нь тэтгэвэрт гарч байгаа улсууд сүүлийн одоо 5, 6, 7 жилийн хугацаанд өндөр татвар төлөөд, сая саяараа тэтгэвэртэй болчихсон байдаг. Нөгөө жинхэнэ ахмадууд маань 500 мянган төгрөгийн тэтгэвэртэй ийм шударга биш байдлаар ингээд тогтчихсон байгаа юм. Энэ тэрийг одоо өөрчлөх шаардлагатай, өөрчлөх шаардлагатай. Тэгээд энийг бол ингээд бид нар бас бодлогын хэмжээнд авч үзээд, ингээд яриад явна гэж ингэж ойлгож байгаа.

Амарбаясгалан дарга хариулах юм уу, үгүй юү? За. Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авлаа.

Зарчмын зөрүүтэй санал бичгээр ирүүлсэн гишүүн байна уу? Алга байна. Одоо энэ чинь Монгол Улсын Үндсэн хуульд өөрчлөлт оруулах өөрчлөлтийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт оруулах санал хураалт явуулъя. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт оруулахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал 85,7 хувиар дэмжигдэж байна. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэх талаар хэлэлцэж дууслаа.

17.18 цаг

Хоёр.Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Дараагийн асуудалд оръё. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн, дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя. Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 39.10-т Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэж заасны дагуу хуулийн төслийг зүйл дээрээ хэлэлцье.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. Хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрээ өгч, нэрсээ өгнө үү? Алга байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Санал хэлэх гишүүн байна уу? Алга байна. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Ингээд дуусчихсан биз дээ. Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо хэлэлцэх асуудлаа хэлэлцэж, уучлаарай. Хэлэлцэж дууслаа. Монгол Улсын Үндсэн хуульд өөрчлөлт оруулах өөрчлөлтийн хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн болон Монгол

Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийг дагаж мөрдөх шилжих журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг ТББХ-ны хуралд Бямбацогт гишүүн танилцуулъя.

17.20 цаг

Гишүүдэд баярлалаа. Хурал дууслаа, хаасныг мэдэгдье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.УЯНГА

